



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

“Соёмбо даатгал” ХХК-д дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-гийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Соёмбо даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн шинэ хувь нийлүүлэгч Ч.Батцогтоос 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараахь байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Ч.Сайнзаяа	548,456,000.0		548,456,000.0	35,42%
2	Ц.Баттулга	500,000,000.0		500,000,000.0	32,29%
3	Ч.Батцогт		500,000,000.0	500,000,000.0	32,29%
	Дүн	1,000,000,000.0	500,000,000.0	1,500,000,000.0	100 хувь

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Соёмбо даатгал” ХХК /Б.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001624